



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

УНШЛАГ

№ 40 (613)

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Авилгатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Болзол батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар  
Улаанбаатар хот  
2009 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвлэл

2009 оны аравдугаар сарын 28 № 40 (613)

Улаанбаатар хот

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

515.	Дугарын Гунгааг Монгол Улсын баатар цолоор шагнах тухай	Дугаар 82	831
516.	Дорнод аймгийн Чойбалсан хотыг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнах тухай	Дугаар 83	831
517.	Охиндойн Цэндсүрэнг албан тушаалд томилох тухай	Дугаар 84	832
518.	Лувсандоржийн Сүхбуяныг албан тушаалд томилох тухай	Дугаар 85	832
519.	Нанзаддоржийн Лүндэндоржийг албан тушаалд томилох тухай	Дугаар 86	832
520.	Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай	Дугаар 113	832
521.	Авилгатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам батлах тухай	Дугаар 120	833
522.	Авилгатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох тухай	Дугаар 121	835

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

523.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 191	836
524.	Болзол батлах тухай	Дугаар 193	836

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

### Дугарын Гунгааг Монгол Улсын баатар цолоор шагнах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15.1-ийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь: 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайн, 1944, 1947 оны баруун хязгаарын зэвсэгт тулгаралтанд оролцож эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалахад амь биеэ үл хайрлан эрэлхэг зоригтой баатарлагаар тулалдсан

түүхэн гавьяаг нь өндрөөр үнэлж Дугарын Гунгаад Монгол Улсын "Баатар" цол олгож, Сүхбаатар одон, "Алтан таван хошуу" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

### Дорнод аймгийн Чойбалсан хотыг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15.1-ийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь: Халхын голын байлдааны ялалтын 70 жилийн ойг тохиолдуулан 1939 оны байлдаан, 1945 оны чөлөөлөх дайны үед эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнол, улс орныг батлан хамгаалах ариун үйл хэрэгт онцгой үүрэг гүйцэтгэсэн

Чойбалсан хотын ард иргэдийн түүхэн гавьяаг нь үнэлж Дорнод аймгийн Чойбалсан хотыг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

Охиндойн Цэндсүрэнг албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Охиндойн Цэндсүрэнг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Уул уурхайн асуудал хариуцсан шинжээчээр томилсугай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

Лувсандоржийн Сүхбуяныг албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Лувсандоржийн Сүхбуяныг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Газрын тосны асуудал хариуцсан шинжээчээр томилсугай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 86

Улаанбаатар хот

Нанзаддоржийн Лүндэндоржийг албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Улсын Ерөнхийлөгчийн орон тооны бус зөвлөхөөр томилсугай.

Нанзаддоржийн Лүндэндоржийг Монгол

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай

Нэг. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 6, "Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль"-ийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн зохицуулагч:

Р.Болд - Ерөнхийлөгчийн эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан, технологийн бодлого, шашны асуудал хариуцсан зөвлөх, доктор

Зөвлөлийн нарийн бичгийн дарга:

О.Жаргалсайхан - Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт

Гишүүд:

1. М.Батчимэг - Ерөнхийлөгчийн үндэсний аюулгүй байдлын бодлогын зөвлөх
2. Д.Баасан - Гүн ухаан, шашны түүх, зурхай судлаач
3. Ж.Батбаясгалан - НИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
4. Х.Батырбек - Монголын Мусульманы нийгэмлэгүүдийн холбооны гүйцэтгэх захирал
5. Б.Билэгт - Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шинжээч
6. Б.Идэрбаяр - Шашны их сургуулийн багш, судлаач
7. А.Жамбал - ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
8. Ч.Куланда - Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд



9. С.Цэдэндамба - МУИС, шашин судлаач, доктор  
 10. Д.Ширэндэв - Монголын "Үлэмж үзэхүй" судлалын төвийн захирал  
 11. О.Энхжаргал - Сүсэгтэн иргэн  
 Хоёр. Энэ зарлиг гарсантай холбогдуулан "Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай" Монгол Улсын

Ерөнхийлөгчийн 2006 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 09 дүгээр зарлигийн 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2009 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр**

**Дугаар 120**

**Улаанбаатар хот**

### Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 1, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Авлигын эсрэг хуул"-ийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийг тус тус баримтлан зарлиг болгох нь;

Нэг. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх "Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

Хоёр. Журмыг шинэчлэн баталсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 195 тоот зарлигаар батлагдсан "Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

### Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 120 дугаар зарлигийн хавсралт

#### АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ОЛОН НИЙТИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

##### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх орон тооны бус олон нийтийн зөвлөлийн /цаашид Зөвлөл гэх/ үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Зөвлөл нь авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Авлигатай тэмцэх газарт зөвлөмж өгөх зорилготой ажиллана.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа шударга, ил тод, хараат бус байх зарчмыг баримтална.

1.4. Зөвлөл нь Авлигатай тэмцэх газрын хараат бус байдал, бие даасан үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандана.

##### Хоёр. Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

2.1. Зөвлөл нь 15 гишүүнээс бүрдэх бөгөөд дараахь дэд зөвлөлтэй /цаашид "Дэд зөвлөл" гэх/ байна:

2.1.1. Бодлогын дэд зөвлөл;

2.1.2. Хүний эрх-үйл ажиллагааны дэд зөвлөл;

2.1.3. Олон нийтийн харилцааны дэд зөвлөл.

2.2. Зөвлөлийн хуралдаанаар зөвлөлийн гишүүдийг Дэд зөвлөлд хуваан харьяалуулна. Зөвлөлийн хуралдаанаас зөвлөлийн даргыг, Дэд зөвлөлийн хуралдаанаар Дэд зөвлөлийн ахлагчийг нэр дэвшүүлэн сонгоно.

##### Гурав. Зөвлөлийн чиг үүрэг

3.1. Зөвлөл иргэний төлөөлөн дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах;

3.1.2. Авлигатай тэмцэх газар хараат бус, ил тод, хууль дээдлэн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих;

3.1.3. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангаж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих;

3.1.4. Авлигатай тэмцэхэд олон нийтийг татан оролцуулах;

3.1.5. Авлигын талаар болон Авлигатай тэмцэх газрын бодлого, үйл ажиллагааны талаарх олон нийтийн санаа бодлыг Авлигатай тэмцэх газарт уламжлах.

3.2. Зөвлөл нь гүйцэтгэх чиг үүргийнхээ хүрээнд Авлигатай тэмцэх газарт зөвлөмж өгнө.

3.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн дүрэмтэй байна.

##### Дөрөв. Дэд зөвлөлийн үйл ажиллагаа

4.1. Дэд зөвлөл гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд дараахь үйл ажиллагаа явуулна.

4.2. Бодлогын дэд зөвлөл:

4.2.1. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны ил тод байдлыг үнэлэх;

4.2.2. Авлигатай тэмцэх газрын захиргаа, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны хараат бус, шударга байдлыг үнэлэх;

4.2.3. Авлигатай тэмцэх газрын төсвийн болон хандивын хөрөнгийн зарцуулалтыг үнэлэх;

4.2.4. Авлигатай тэмцэх газраас явуулж буй үйл ажиллагаа хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж, зөрчиж байгаа эсэхэд үнэлгээ өгөх;

4.2.5. Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаар Улсын Их Хуралд мэдээлэх мэдээлэлд хөндлөнгийн үнэлгээ өгөх;

4.2.6. Зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний биелэлтийн тухай мэдээлэл, тайлбар Авлигатай тэмцэх газраас авах.

4.3. Хүний эрх – үйл ажиллагааны дэд зөвлөл:

4.3.1. Авлигатай тэмцэх газарт ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн тухай мэдээлэл авах;

4.3.2. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа, шийдвэрийн талаар иргэн, байгууллага, албан тушаалтнаас өргөдөл, гомдол хүлээн авах, танилцаж, холбогдох этгээдээс тайлбар авах;

4.3.3. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан өргөдөл, гомдолтой танилцаж, уг шийдвэрийг гаргасан албан тушаалтнаас тайлбар авах;

4.3.4. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний талаар Авлигатай тэмцэх газарт зөвлөх;

4.3.5. Авлигатай тэмцэх газраас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн шүүхээр шийдвэрлэсэн байдалтай танилцаж;

4.3.6. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд туслалцаа үзүүлсэн этгээд, гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр авч буй арга хэмжээтэй танилцаж.

4.4. Олон нийтийн харилцааны дэд зөвлөл:

4.4.1. Авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаар иргэдийн санаа бодлыг судлах;

4.4.2. Нийгмийн хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний явц, үр дүнтэй танилцаж;

4.4.3. Төрийн байгууллагын хүрээнд авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, хөтөлбөрүүдийн талаар авлигатай тэмцэх газраас авч буй арга хэмжээ, явц, үр дүнтэй танилцаж;

4.4.4. Олон нийтэд Авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг тайлбарлан таниулах үйл ажиллагаанд оролцох;

4.4.5. Зөвлөлийн үйл ажиллагаа, Авлигатай тэмцэх газарт өгсөн зөвлөмжийг олон нийтэд мэдээлэх;

4.4.6. Иргэдийг соён гэгээрүүлэх, иргэдийг авлигатай тэмцэх үйл ажиллагаанд оролцуулахад дэмжлэг үзүүлэх.

### Тав. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр

5.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хуралдаан /цаашид "хуралдаан" гэх/ байна.

5.2. Зөвлөлийн нэгдсэн хуралдааныг улиралд 2-оос доошгүй удаа, дэд зөвлөлийн хуралдааныг зарласанаар хийх ба гишүүдийн олонхи хүрэлцэн ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцно.

5.3. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн дарга, гишүүд санал болгоно.

5.4. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг санал болгож болно.

5.5. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцож чадаагүй Зөвлөлийн гишүүн Зөвлөл, Дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлаар урьдчилан саналаа хүргүүлсэн тохиолдолд түүний хуралдаанд оролцсон тооцно. Энэ тохиолдолд Зөвлөл, Дэд зөвлөлийн дарга хуралдаанд биелчлэн оролцож буй гишүүд хэлэлцэж буй асуудлаар саналаа гаргасны дараа саналаа урьдчилан хүргүүлсэн гишүүний саналыг танилцуулж санал хураахад оруулан тооцно.

5.6. Зөвлөл гүйцэтгэсэн ажлаа Монгол Улсын Ерөнхийлөгчид жил бүр тайлагнана. Зөвлөл шаардлагатай гэж үзсэн асуудлаар тухай бүрд нь Ерөнхийлөгчид мэдээлж болно.

5.7. Зөвлөл үйл ажиллагааны тайланг жил бүр, АТГ-т өгсөн зөвлөмжийг тухай бүрд нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

### Зургаа. Зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрх

6.1. Зөвлөлийн дарга, гишүүн нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг баримтлан ажиллаж дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Зөвлөлийн дарга нь 6.3.-т зааснаас гадна дараахь бүрэн эрхийг эдэлнэ:

6.1.1. Зөвлөлийг төлөөлж Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллага, иргэдтэй харилцаж;

6.1.2. Зөвлөлийн хуралдааны товыг зарлан зохион байгуулж удирдан явуулах;

6.1.3. Зөвлөлийн хуралдаанаас гаргасан зөвлөмжийг Авлигатай тэмцэх газрын даргад өгөх;

6.1.4. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлын төсөө, тооцоог гаргах;

6.1.5. Зөвлөлийн ажлыг төлөвлөн зохион байгуулж, удирдах.

6.2. Дэд зөвлөлийн ахлагч нь 6.3-т зааснаас гадна дараахь бүрэн эрхийг эдэлнэ:

6.2.1. Дэд зөвлөлийн хурлын товыг зарлан зохион байгуулж, удирдан явуулах;

6.2.2. Зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг Зөвлөлийн даргад танилцуулж зөвшөөрлийг нь авсны үндсэн дээр хуралдаанд оруулах;

6.2.3. Дэд зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой хуулиар хориглоосноос бусад мэдээ, мэдээллийг Авлигатай тэмцэх газраас гаргуулан авах;

6.3. Зөвлөлийн гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.3.1. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар өөрийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх;

6.3.2. энэхүү журмын 4.1-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх талаар санал, санаачилга гаргах;





6.3.3. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллах;

6.3.4. Улс төрийн нам, аливаа эвсэл, хөдөлгөөний шахалт, шаардлагад автахгүй байх;

6.3.5. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээс бусад тохиолдолд Зөвлөлийн хуралдаан болон Дэд зөвлөлийн хуралд оролцож байх;

6.3.6. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай холбоотой нууцлал зохих мэдээ, мэдээллийг задруулахгүй байх.

## Долоо. Авлигатай тэмцэх газрын эрх, үүрэг

7.1. Авлигатай тэмцэх газар нь Зөвлөлтэй хамтран ажиллах талаар дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1. Зөвлөл, Дэд зөвлөлийн хуралдаанаас 3 хоногийн өмнө түүний зар болон хуралдаанд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Зөвлөлийн гишүүдэд хүргэх;

7.1.2. Зөвлөл, Дэд зөвлөлийн хуралдаан явуулах байр, шаардлагатай техник хэрэгсэлээр хангах, үйл ажиллагаанд шаардагдах зардлыг гаргаж өгөх;

7.1.3. Зөвлөлийн хуралдаанаас гарсан, хууль тогтоомжид нийцсэн Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд ингэж үзэх болсон шалтгаан, үндэслэлийг Зөвлөмжид заасан хугацаанд эргүүлэн мэдэгдэх;

7.1.4. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай бусад тусалцаа, дэмжлэг үзүүлэх ба хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хамтран ажиллах;

7.1.5. Зөвлөлд хандан авлигатай тэмцэх тодорхой асуудлаар дэмжлэг тусалцаа хүсэх;

7.1.6. Зөвлөлийн болон Зөвлөлийн гишүүний авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагаанд харш үйлдэл, үйл ажиллагааны талаар анхааруулга өгөх;

7.1.7. Хуульд өөрөөр заагаагүй бол Зөвлөлийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;

7.1.8. Авлигатай тэмцэх газрын удирдлагын зөвлөлийн гишүүн нь Зөвлөлийн хүсэлтээр

хуралдаанд оролцож, тус газрын бодлого, үйл ажиллагааны талаар тайлбар өгөх, хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар саналаа хэлэх.

7.2. Зөвлөлтэй хамтран ажиллах үүргийг Авлигатай тэмцэх газрын дарга, түүний эзгүйд дэд дарга хэрэгжүүлнэ.

7.3. Авлигатай тэмцэх газар Зөвлөлийн үйл ажиллагаанд туслах үүрэгтэй ажилтан ажиллуулна. Ажилтан нь зөвлөлийн хуралдааны зар түгээх, хуралдааны тэмдэглэл хөтлөх, Зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг Авлигатай тэмцэх газарт хүргэх, Зөвлөл үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зохион байгуулалтын ажлыг хариуцна.

## Найм. Зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх

8.1. Авлигын эсрэг хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан иргэнийг Зөвлөлийн гишүүнээр Монгол Улсын Ерөнхийлөгч томилно.

8.2. Зөвлөлийн гишүүнийг шалгаруулахдаа хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр зарлаж өөрөө хүсэлтээ гаргасан, бусдын санал болгосон төрийн бус байгууллагын төлөөлөгч, иргэдээс авлигатай тэмцэх чиглэлээр ажиллах хүсэл сонирхол, чадвар, туршлага, олон нийтийн эрх ашгийг илэрхийлэх, тэднийг авлигатай тэмцэх үйл ажиллагаанд татан оролцуулах чадварыг шалгуур болгоно.

8.3. Зөвлөлийн гишүүнийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө дараахь үндэслэлээр чөлөөлнө:

8.3.1. Төрийн, улс төрийн болон төрийн жинхэнэ албанд сонгогдсон эсхүл томилогдсон, бусад шалтгаанаар иргэний нийгмийг төлөөлөхгүй болсон;

8.3.2. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол гарсан;

8.3.3. Чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;

8.3.4. Зөвлөлийн болон Дэд зөвлөлийн үйл ажиллагаанд хүндэтгэх шалтгаангүйгээр оролцохгүй болсон;

8.4. Зөвлөлийн гишүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч чөлөөлнө.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 121

Улаанбаатар хот

### Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Авлигын эсрэг хууль"-ийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нэг. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийг хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Хоёр. Олон нийтийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилсонтой холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах" тухай 2007 оны 209 тоот зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



## Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 121 дүгээр зарлигийн хавсралт

### АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ОЛОН НИЙТИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Р.Бурмаа, Сонгогчдын боловсрол төв
2. Ж.Батзандан, Иргэний хөдөлгөөн
3. П.Эрдэнэжаргал, Нээлттэй нийгэм форум ТББ
4. Р.Батсайхан, Нирун фильм студи
5. Г.Даваахүү, Глоб Интернэшнл ТББ
6. Б.Гэрэлмаа, Зориг сан
7. Ж.Мөнх-Эрдэнэ, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
8. Д.Сүхбаатар, МУИС-ийн НШУС

9. Г.Баярцэцэг, Судлаач, Нээлттэй нийгэм форумын зөвлөх
10. Ш.Цогтоо, МУИС-ийн Хууль зүйн сургууль
11. А.Баатархуяг, 25 дугаар суваг телевиз
12. Ц.Энхцэнгэл, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
13. М.Ичинноров, Эрх зүйн шинэтгэлийг дэмжих төв
14. Т.Хасбаатар, Нэг ардчилал клуб
15. Г.Байгальмаа, Ардчилал сан

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 191

Улаанбаатар  
хот

#### Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2009 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Люксембург хотноо гарын үсэг зурсан "Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Их Гүнт Улсын

Засгийн газар хоорондын соёлын хэлэлцээр"-ийг баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

Е.ОТГОНБАЯР

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 193

Улаанбаатар  
хот

#### Болзол батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Улсын тэргүүний /загвар/ сум шалгаруулах болзол"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Улсын тэргүүний /загвар/ сумыг 2 жил тутам шалгаруулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгорт даалгасугай.

3. Улсын тэргүүний /загвар/ сумдад олгох шагналд шаардагдах хөрөнгийг 2010 оноос эхлэн болзлыг дүгнэх тухайн жилийн улсын төсөвт тусган

санхүүжүүлж байхыг Сангийн сайд С.Баярцогт, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгор нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Б.ДОЛГОР

Засгийн газрын 2009 оны 193 дугаар  
тогтоолын хавсралт

### УЛСЫН ТЭРГҮҮНИЙ /ЗАГВАР/ СУМ ШАЛГАРУУЛАХ БОЛЗОЛ

#### Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгж болхос сумын нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах замаар төрөөс орон нутгийн иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний хөнгөн шуурхай байдал, чанар, хүртээмжийг дээшлүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэн татварын орлогын суурийг нэмэгдүүлэх,

ажилгүйдэл, ядуурлыг бууруулан иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлж, тэдгээрийн нутагтаа тав тухтай, тогтвор суурьшилтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд болзлын зорилго оршино.

1.2. Болзлыг 2 жил тутам дүгнэж, шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан 4 сум (бүс бүрээс 1 сум)-ыг шалгаруулна.

## Хоёр. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Улсын тэргүүний /загвар/ сумаар тодорхойлогдож байгаа сум дараахь шалгуур үзүүлэлтийг хангасан байна:

2.1.1. Хууль тогтоомжоор Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгосон чиг үүрэг бүрэн хэрэгжиж үйл ажиллагааны үр нөлөө нь дээшилж, Хурал, Тэргүүлэгчдийн шийдвэрийн биелэлт хангагдан үр дүнд хүрч, иргэдээс дэмжлэг, зөргө үнэлгээ авсан байх;

2.1.2. Хурлын бүтцийн байгууллага /Тэргүүлэгчид, хороо-уудын үйл ажиллагаа тогтмолжиж, тэдгээрт оролцох төлөөлөгчдийн оролцоо, үүрэг хариуцлага сайжирсан байх;

2.1.3. Багийн иргэдийн Нийтийн Хурал, Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны үр нөлөө дээшилж ажлын тодорхой үр дүнд хүрч, тэдгээрт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс Үзүүлэх мөргөшил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг тогтмолжсон байх;

2.1.4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлыг бүрэн тусгасан байх, тухайн жилд дэвшүүлсэн зорилт бүрэн биелэгдэж, ажлын тодорхой ахиц өөрчлөлт гарч, үр дүнд хүрсэн байх;

2.1.5. Хууль тогтоомжид заасан Засаг даргын Тамгын газрын чиг үүрэг бүрэн хэрэгжиж, газрын үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай үзүүлж, чирэгдэлгүй үйлчилгээний дэвшилтэт арга барилыг нэвтрүүлэн байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг хангасан байх;

2.1.6. Багийн Засаг дарга нарын ажиллах нөхцөл бололцоо сайжирч, тэдний зүгээс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байх;

2.1.7. Засгийн газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамжийг биелүүлэх ажлыг шуурхай хэрэгжүүлж, заалт бүрийн биелэлт, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг дүгнэж, улирал бүр Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж хэвшсэн байх;

2.1.8. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан төсвийн зардлыг хэтрүүлээгүй, тайлангийн хугацаанд өр, авлага үүсгээгүй, татварын орлогын суурийг өргөтгөн өөрөө өөрийгөө санхүүжүүлэх, нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг бие даан шийдвэрлэх боломжийг бүрдүүлж, татварын орлогын төлөвлөгөө бүрэн биелүүлсэн байх;

2.1.9. Өрх, иргэд хувиараа хөдөлмөр эрхлэх бололцоог бүрдүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн онцлог тохирсон жижиг, дунд үйлдвэрлэл шинээр эрхлэх болон тогтвортой үйл ажиллагаа эрхлэж байгаа үйлдвэрлэл эрхлэгчдийг зээл олгох, төсөл, хөтөлбөрт хамруулах зэрэг хэлбэрээр хөхүүлэн дэмжиж бодит ажилгүйдлийг 80-аас доошгүй хувиар бууруулсан байх;

2.1.10. Сум, багаараа ядуурлаас гарах хөдөлгөөн өрнүүлж, иргэд, төрийн бие байгууллагын үүсгэл санаачилгыг чиглүүлэн бодит үр дүн гаргах ядуу өрх, иргэний тоог бууруулан, сумаас шилжин сууршигчдын тоог бууруулж, шилжин иргэдийн тоог нэмэгдүүлсэн байх;

2.1.11. Сумын эмнэлгийн үйл ажиллагааг стандартын дагуу явуулах нөхцөлийг бүрдүүлж, жирэмсэн эхчүүдийг 100 хувь хяналтад авч эмнэлэгт буюу эмчийн тусламжтайгаар төрүүлэн, эхчүүдийн амрах байранд амрах арга хэмжээ авсан байх;

2.1.12. Халдварт өвчний гаралт, мянган хүн тутамд ногдох өвчлөл, эхийн нас баралт, хүүхдийн

эндэгдэл улс, аймгийн дунджаас буурсан, хүн бүр халуун усанд орох бололцоог бүрэн хангасан байх;

2.1.13. Гэмт хэрэг, хэв журмын зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажил сайжирч, арихдан согуурахын эсрэг хийх ухуулга, сурталчилгааг уламжлалт зан заншилтай хослуулснаар тодорхой үр дүнд хүрсэн байх;

2.1.14. Сумын төвийг хөгжлийн өрөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлж, байгууллага, айв өрхийн тохижилт, орон сууцны хангамж сайжирч, хүн амыг ундны усаар бүрэн хангасан байх, хог хаягдлыг цэвэрлэх, нэгдсэн хогийн цэгт хаях асуудлыг шийдвэрлэн золбин нохой, муургүй болсон байх;

2.1.15. Сургуулийн өмнөх болон өрөнхий боловсролын хамран сургалт, боловсролын стандартын хангалтын хувь улс, аймгийн дунджаас дээгүүр байх;

2.1.16. Байгаль орчны хамгаалах, сумын төвийг цэцэрлэгжүүлэх, шинээр мод тарих ажилд иргэдийн оролцоог хангаж, тодорхой үр дүнд хүрсэн байх;

2.1.17. Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах ажлыг тогтмолжуулсан байх;

2.1.18. Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар өрх, иргэд орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж, бэлчээрийг улирлын хуваарьтай ашиглах, хамгаалах арга хэмжээ авсан байх;

2.1.19. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй, баталгаат байдлыг хангах зорилгоор мал эмнэлэг, үржлийн ажлын чанар, хүртээмжийг дээшлүүлж, малын халдварт, паразиттай өвчний гаралтыг бууруулсан байх.

## Гурав. БОЛЗЛЫГ ДҮГНЭХ

3.1. Аймгийн Засаг даргын Тамгын газраас энэхүү болзлын дагуу шалгаруулах сумын ажлыг газар дээр нь шалган дүгнэж, аймгийн Засаг даргын зөвлөлийн болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн, энэхүү болзлын шалгуур үзүүлэлт болон хавсралтад заасан эдийн засаг, нийгмийн үзүүлэлт бүрээр дүгнэсэн материалын хамт тухайн аймаг, сумын харьяалагдах бүсийн зөвлөлд 2 дугаар сарын 20-ны дотор хүргүүлнэ.

3.2. Бүсийн зөвлөл материалыг хүлээн авч сумдын ажлыг газар дээр нь шалгаж, дүнг бүсийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, шалгаруулах сумын материалыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ.

3.3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас томилгогдсон ажлын хэсэг болзлын дагуу шалгаруулахаар нэг дэвшүүлсэн сумдын ажлыг газар дээр нь шалгаж, дүнг мөн оны 2 дугаар сарын 1-ний дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

3.4. Болзлын шалгуур үзүүлэлтийг бүрэн биелүүлж шалгарсан сумыг гэрчилгээ, 100.0 сая төгрөгөөр шагнаж, сар шинийн барьен өмнө гардуулна.

3.5. Шагналын мөнгөний 90.0 хувийг тухайн суманд үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зээл олгох, сумын төвийн тохижилтыг сайжруулах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд зарцуулна. Шагналын мөнгийг зарцуулах асуудлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

3.6. Шалгарсан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газрын ажилтан, багийн Засаг дарга, Иргэдийн Нийтийн Хурлын дарга, сумын төсвийн болон төрийн бие байгууллагын ажилтан нараас 45 хүртэл хүнийг нэг сарын үндсэн цагн хүртэл хэмжээний мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.





## Засгийн газрын 2009 оны 193 дугаар тогтоолоор баталсан болзлын хавсралт

### .....СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайланг он	Өөрчлөлт
1.	<b>Эдийн засгийн үзүүлэлт</b> Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт /хувь/ Төсвийн нийт зардалд өөрийн орлогын эзлэх хувь Төсвийн зарлагын хэтрэлт, хэмнэлт /сая.төг/ Төсвийн өр, авлага /сая.төг/ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт /сая.төг/ Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт /сая.төг/ Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл /сая.төг/ Нэг хүнд ногдох хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн /мян.төг/ Малын тоо /мян.толгой/ Тариалсан талбай /мян.га/ Бэлтгэсэн хадлан /мян.тонн/ Хураан авсан үр тариа /мян.тонн/ Төмс, хүнсний ногоо /мян.тонн/ Тэжээлийн ургамал /мян.тонн/ Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн барилга-угсралт, их засварын ажил /зэрэгцүүлэх үнээр, сая.төг/ Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь			
2.	<b>Нийгмийн үзүүлэлт</b> Бага боловсролын хамран сургалтын хувь Суурь боловсролын хамран сургалтын хувь Бүрэн дунд боловсролын хамран сургалтын хувь Анги дүүргэлт Сурлагын амжилт Сурлагын чанар Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт /хувь/ Сургуулийн өмнөх боловсролын мэргэжлийн багшийн хангалт /хувь/ 6 настай хүүхдийн хамран сургалт Сургуулийн гадна байгаа 6-15 насны хүүхдийн тооны индекс Сумын хүн амд үйлчлэх номын сангийн фондын баяжилт /тоо/ Хүн амын дундаж нас Эхийн эндэгдлийн түвшин Нялхсын эндэгдэл /1000 хүүхдэд ногдох/ Халдварт өвчний тохиолдол /10000 хүнд ногдох/ Урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан байдал /хувь/ Ажилгүйдлийн түвшин Ядуурлын индекс Хүн амын дундаж орлого, амьжиргааны баталгаажих доод түвшингийн харьцаа /хувь/ Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент /хувь/ Цэрэг татлагын төлөвлөгөөний биелэлт Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо Шүүхээр ял шийтгүүлсэн яллагдагсдын тоо Согуугаар гэмт хэрэг үйлдсэн хүний тоо			
3.	<b>Хөгжлийн үзүүлэлт</b> Шинээр ашиглалтад оруулсан хатуу хучилттай болон сайжруулсан замын урт /км/ Ойжуулсан талбай /мян.га/ Шинээр ашиглалтад оруулсан орон сууц /тоо/ Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт /сая.төг/ Шинээр ашиглалтад оруулсан жижиг, дунд үйлдвэрийн тоо Шинээр бий болсон ажлын байрны тоо Шинээр гаргасан болон сэргээн засварласан уст цэгийн тоо Халуун усны тоо			

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12  
Төрийн ордон-128 тоот  
и-мэйл: turin\_medeefel@parliament.mn

☎ 252420, 329612  
Индекс 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 1

Засгийн газрын 2009 оны 193 дугаар  
тогтоолоор баталсан болзлын хавсралт

.....СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН  
ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайланг он	Өөрчлөлт
1.	Эдийн засгийн үзүүлэлт Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт /хувь/ Төсвийн нийт зардалд өөрийн орлогын эзлэх хувь Төсвийн зарлагын хэтрэлт, хэмнэлт /сая.төг/ Төсвийн өр, авлага /сая.төг/ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт /сая.төг/ Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт /сая.төг/ Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл /сая.төг/ Нэг хүнд ногдох хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн /мян.төг/ Малын тоо /мян.толгой/ Тариалсан талбай /мян.га/ Бэлтгэсэн хадлан /мян.тонн/ Хураан авсан үр тариа /мян.тонн/ Төмс, хүнсний ногоо /мян.тонн/ Тэжээлийн ургамал /мян.тонн/ Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн барилга-угсралт, их засварын ажил /зэрэгцүүлэх үнээр, сая.төг/ Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь			
2.	Нийгмийн үзүүлэлт Бага боловсролын хамран сургалтын хувь Суурь боловсролын хамран сургалтын хувь Бүрэн дунд боловсролын хамран сургалтын хувь Анги дүүргэлт Сурлагын амжилт Сурлагын чанар Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт /хувь/ Сургуулийн өмнөх боловсролын мэргэжлийн багшийн хангалт /хувь/ 6 настай хүүхдийн хамран сургалт Сургуулийн гадна байгаа 6-15 насны хүүхдийн тооны индекс Сумын хүн амд үйлчлэх номын сангийн фондын баяжилт /тоо/ Хүн амын дундаж нас Эхийн эндэгдлийн түвшин Нялхсын эндэгдэл /1000 хүүхдэд ногдох/ Халдварт өвчний гохиолдол /10000 хүнд ногдох/ Урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан байдал /хувь/ Ажилгүйдлийн түвшин Ядуурлын индекс Хүн амын дундаж орлого, амьжиргааны баталгаажих доод түвшингийн харьцаа /хувь/ Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент /хувь/ Цэрэг татлагын төлөвлөгөөний биелэлт Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо Шүүхээр ял шийтгүүлсэн яллагдагсдын тоо Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн хүний тоо			
3.	Хөгжлийн үзүүлэлт Шинээр ашиглалтад оруулсан хатуу хучилттай болон сайжруулсан замын урт /км/ Ойжуулсан талбай /мян.га/ Шинээр ашиглалтад оруулсан орон сууц /тоо/ Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт /сая.төг/ Шинээр ашиглалтад оруулсан жижиг, дунд үйлдвэрийн тоо Шинээр бий болсон ажлын байрны тоо Шинээр гаргасан болон сэргээн засварласан уст цэгийн тоо Халуун усны тоо			

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон-128 тоот  
и-мэйл: turin\_medeel@parliament.mn

☎ 262420, 329612  
Индекс 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 1